



ИНД-67 Эрүүл мэндийн стандартын ангилал

Хамаарал	1-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ (67.103)		2-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ (67.105)		3-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ (67.107)	
	Агаарын тээвэрлэгчийн нисгэгч, Коммерийн нисгэгч, Нисэх инженер		Хувийн нисгэгч, Сурагч нисгэгч		Нислэгийн хөдөлгөөний удирдагч, Сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагч	
Үзлэгийн хугацаа	(a) Энэ зүйлийн (c) болон (e)-г харгалзан, Дарга ЭМГ-г дараах хугацаагаар олгож болно: (1) 1-р ангиллын ЭМГ: (i) 6 сар хүртэлх хугацаагаар, ганц нисгэгчтэй зорчигч тээвэрлэх иргэний агаарын тээврийн үйл ажиллагааны хувьд, хэрэв хүсэлт гаргагч нь ЭМГ олгох үед 40, эсхүл түүнээс дээш настай бол; эсхүл (ii) 12 сар хүртэлх хугацаагаар, бусад бүх тохиолдолд;	(2) 2-р ангиллын ЭМГ: (i) 60 сар хүртэлх хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40-өөс доош настай бол; эсхүл (ii) 24 сар хүртэлх хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40, эсхүл түүнээс дээш настай бол;	(3) 3-р ангиллын ЭМГ (i) 48 хүртэлх сарын хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40-өөс доош настай бол; эсхүл (ii) 24 сар хүртэлх хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40, эсхүл түүнээс дээш настай бол.			
Нас	Коммерийн нисгэгч - 18, Агаарын тээвэрлэгчийн нисгэгч - 21		Сурагч нисгэгч - 16, Хувийн нисгэгч - 17		Нислэгийн хөдөлгөөний сурагч - 18, Нислэгийн хөдөлгөөний удирдагч - 21,	
1. Ерөнхий шаардлага	(a) Энэ зүйлийн (b)-ээс (m)-д заасан стандартыг хангаж байгаа хүсэлт гаргагчийг <u>холбогдох</u> ангиллын ЭМГ-ний стандарт хангасанд тооцно. (b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах эрүүл мэндийн нөхцөлгүй байх; (2) энэ зүйлийн (b)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх: (i) хэвийн бус байдал; (ii) хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл өвчтэй (идэвхтэй, эсхүл нуугдмал); (iii) осол, гэмтэл, эсхүл мэс заслын үр дагавар; (iv) физиологийн, эсхүл эмгэг зүйн явц; (v) хорт хавдрын явц; (vi) ядаргаа үүсгэх нөхцөл; (vii) халдвар, тохирох эмчилгээ, эсхүл эмчилгээний шийдэл, эсхүл аль аль нь тодорхой байхаас бусад тохиолдолд; (3) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, <u>холбогдох</u> ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй дараах нөхцөлгүй байх: (i) аливаа эм, эмийн бодис, эмийн бэлдмэл хэрэглэдэг, эсхүл тухайн цаг хугацаанд эмчилгээнд бэлдэж байгаа, эсхүл хийлгэж байгаа; эсхүл (ii) аливаа эм, эмийн бодис, эмийн бэлдмэл, эмчилгээний бэлтгэл, эсхүл эмчилгээнээс үүдэлтэй аливаа гаж нөлөөнд орсон.					
2. Мэдрэлийн Эрхтэн тогтолцоо	(c) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах аливаа мэдрэлийн, мэдрэлийн мэс заслын, сэтгэцийн, эсхүл сэтгэл зүйн нөхцөлийн, эсхүл зан төлөвийн, эсхүл танин мэдэхүйн эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх; (2) энэ зүйлийн (c)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх: (i) мэдрэлийн эрхтэн тогтолцооны аливаа бүрэлдэхүүн хэсгийн өвчин, эсхүл эмгэг; (ii) мигрень /толгой таллаж өвдөх/, эсхүл бусад хүнд хэлбэрийн толгойн өвчин; (iii) сэтгэхүйн, эсхүл үйл хөдлөлийн хэвийн бус байдал; (iv) сэтгэцийн өөрчлөлтийн нөхцөл; (v) солиорол; (vi) зан чанарын эмгэг; (vii) сэтгэцийн хэвийн бус байдал, эсхүл невроз; (viii) сэтгэл гутрал; (ix) бэртлийн дараах стрессийн эмгэг; (x) мэдрэлийн мэс засал, эсхүл тархины гэмтлийн үр дагавар; (3) энэ зүйлийн (c)(1)-ээр хязгаарлахгүйгээр, татаж унадаг өвчний, эсхүл түүнээс үүдэлтэй таталт өгдөг эрсдэл ихэссэнтэй холбоотой бусад нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх; (4) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, <u>холбогдох</u> ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн онош, эсхүл өвчний түүхгүй байх; (5) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, <u>холбогдох</u> ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэдэггүй байх.					
3. Зүрх судасны эрхтэн тогтолцоо	(d) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах зүрх судасны, эсхүл цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх; (2) энэ зүйлийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх: (i) зүрхний титэм судасны өвчин; (ii) зүүн багцын салааны хориг; (iii) баруун багцын салааны хориг, ишемигийн шалтгааныг арилгаснаас бусад тохиолдолд; (iv) цусны даралт тогтворгүй ихсэх; (v) зүрхний булчингийн, хавхлагын, эсхүл дамжуулах тогтолцооны хэвийн бус байдал; (vi) зүрхний хэмнэлийн хэвийн бус байдал; (3) энэ зүйлийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, зүрхний электрон төхөөрөмж шаарддаг эмгэггүй байх; (4) зүрх судасны өвчний өндөр эрсдэлийн хүчин зүйл байхгүй байх, зүрхний булчингийн перфузийн хэвийн үйл ажиллагааг баталж чадахаас бусад тохиолдолд.					
4. Амьсгалын замын эрхтэн тогтолцоо	(e) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах амьсгалын замын эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх; (2) энэ зүйлийн (e)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох гуурсан хоолойн багтраа өвчний онош, эсхүл түүхгүй байх, зөвхөн урьдчилан сэргийлэх зорилгоор кортикостероид эмчилгээ хэрэглэдэг, тогтмол хяналтад байдгаас бусад тохиолдолд. (2) энэ зүйлийн (e)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох гуурсан хоолойн багтраа өвчний онош, эсхүл түүхгүй байх, <u>зөвхөн урьдчилан сэргийлэх зорилгоор кортикостероид эмчилгээ хэрэглэдэг, тогтмол хяналтад байдгаас бусад тохиолдолд.</u> (2) энэ зүйлийн (e)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох гуурсан хоолойн багтраа өвчний онош, эсхүл түүхгүй байх, зөвхөн урьдчилан сэргийлэх зорилгоор кортикостероид эмчилгээ хэрэглэдэг, тогтмол хяналтад байдгаас бусад тохиолдолд.					
5. Хоол боловсруулах болон дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцоо	(f) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах хоол боловсруулах, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх; (2) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх: (i) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц; (ii) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар; (iii) энэ хэсгийн (3)-т зааснаас бусад, бодисын солилцоо, хоол тэжээл, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эмгэг; (3) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, дараахаас бусад тохиолдолд, чихрийн шижин, эсхүл хэвийн бус глюкозын ямар ч шинж тэмдгийн онош, эсхүл түүхгүй байх: (i) чихрийн шижингийн эсрэг аливаа эмийн бодис хэрэглэхгүйгээр, тухайн нөхцөл байдлыг хангалттай түвшинд хянадаг бол; эсхүл (ii) хэрэв тухайн нөхцөл байдлыг хянахын тулд чихрийн шижингийн эсрэг эмийн бодис уухаар хэрэглэдэг бол: (iia) тухайн нөхцөл байдал нь эмчийн тогтмол үзлэг, хяналтад байх; (iib) инсулин хэрэглэдэггүй байх; (iic) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, тухайн хэрэглэж байгаа уудг эмийн бодисыг дангаар болон хавсран хэрэглэх нь <u>холбогдох</u> ангиллын ЭМГ-нд хамаарах эрх, үүргээ аюулгүй хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй ба бараг нөлөөлөхөөргүй байх.					
6. Цус болон дархлааны эрхтэн тогтолцоо	(g) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах цус болон дархлааны эрхтэн тогтолцооны аливаа өвчний онош, эсхүл түүхгүй байх; (2) энэ зүйлийн (g)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх: (i) дэлүү томрох, цус төлжүүлэлт /миелополизифератив/ болон халдварын шалтгааныг арилгаснаас бусад тохиолдолд; (ii) тодорхой хэсгийн, эсхүл бүх биеийн тунгалгийн булчирхай томрох; (iii) цусны өвчин, эсхүл цус, эсхүл түүний бүрдэл хэсгийн өвчний нөхцөл байдал; (iv) дархлаа сулрах, эсхүл хэт идэвхжихтэй холбоотой эмгэг, эсхүл нөхцөл байдал.					
7. Шээс - бэлгийн замын эрхтэн тогтолцоо	(h) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх; (2) энэ зүйлийн (h)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх: (i) шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал, эсхүл өвчин; (ii) шээс-бэлгийн замын өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар; (iii) бөөр, эсхүл шээсний зам бөглөрсөн, эсхүл бөглөрөх эрсдэл ихэссэн.					
8. Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо	(i) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх; (2) энэ зүйлийн (i)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх: (i) сарын тэмдгийн мөчлөгийн алдагдал; (ii) жирэмслэлт.					
9. Яс-булчингийн эрхтэн тогтолцоо	(j) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах яс-булчингийн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх; (2) энэ зүйлийн (j)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх: (i) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин-шөрмөсний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц; (ii) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин шөрмөсний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар.					
10. Чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцоо	(k) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх; (2) энэ зүйлийн (k)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх: (i) гадна, дунд, эсхүл дотор чихний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц; (ii) шүд, ам, эсхүл амьсгалын дээд замын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц; (iii) евстахиевийн сувгийн битүүрэл, эсхүл дунд чихний хэвийн бус байдал; (iv) тэнцвэрийн эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал. (iii) <u>евстахиевийн сувгийн битүүрэл, эсхүл дунд чихний хэвийн бус байдал;</u> (iii) тэнцвэрийн эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал.					
11. Сонстгол	(l) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах аливаа сонсголын эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх; (2) энэ зүйлийн (l)(1)-ээр хязгаарлахгүйгээр, аль ч чихний сонсох чадварын дутагдал нь дараахаас хэтэрсэн онош, эсхүл түүхгүй байх: (i) 500, 1000, 2000Гц-ийн давтамж тус бүрд 35дб; эсхүл (ii) НЭМОШ-д хүргэж болох 3000Гц-ийн давтамжид 50дб. (2) энэ зүйлийн (l)(1)-ээр хязгаарлахгүйгээр, <u>дуу хоолойн төстөд аль ч чихний сонсох чадварын дутагдал илрээгүй,</u> эсхүл дараахаас хэтрээгүй байх : (2) энэ зүйлийн (l)(1)-ээр хязгаарлахгүйгээр, аль ч чихний сонсох чадварын дутагдал нь дараахаас хэтэрсэн онош, эсхүл түүхгүй байх:					
12. Хараа	(m) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) НЭМОШ-д хамаарах аливаа харааны эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх; (2) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх: (i) нүд, эсхүл түүний дайврын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц; (ii) нүд, эсхүл түүний дайврын өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар; (iii) харааны талбайн, эсхүл хос харааны үзүүлэлтүүдийн хэвийн бус байдал; (iv) мэс заслаас үүдэлтэй аль нэг нүдний харааны хугарлын өөрчлөлт; (3) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, холын хараа нь хоёр нүдэнд тус тусдаа шилтэй, эсхүл шилгүй 6/9, эсхүл илүү харах болон хос хараа нь 6/6, эсхүл илүү харах; (4) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, ойрын хараа нь шилтэй, эсхүл шилгүйгээр N5-ын дүрсийг, эсхүл хос хараагаар 30 - 50см-ийн хоорондох зайнаас илүү харах болон дундын хараа нь N14 дүрсийг, эсхүл хос хараагаар 1м-ийн зайнаас илүү харах; (5) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох өнгө ялгаж чадварын дутагдал илрээгүй байх. (3) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, холын хараа нь хоёр нүдэнд тус тусдаа шилтэй, эсхүл шилгүй 6/12, эсхүл илүү харах болон хос хараа нь 6/9, эсхүл илүү харах; (4) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, ойрын хараа нь шилтэй, эсхүл шилгүйгээр N5-ын дүрсийг, эсхүл хос хараагаар 30 - 50см-ийн хоорондох зайнаас илүү харах болон дундын хараа нь N14 дүрсийг, эсхүл хос хараагаар 1м-ийн зайнаас илүү харах;					